



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04-р сарын 29-ны өдөр

Улаанбаатар хот

Хурал: 2024 оны 04 сарын 29-ны өдрийн 15.00 цагт Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Туушин зочид буудал, Сүлд танхимд хийгдсэн.

Хурлын ирц бүртгэл, санал хураалтыг Си Эм Си Консалтинг ХХК-ийн боловсруулсан hural.basaltwool.mn цахим хуудас ашиглан явуулсан болно.

Хурлын ирц: Хуралд нийт 39,756,853 ширхэг хувьцаа эзэмшиж буй 47 хувьцаа эзэмшигч өөрөө биечлэн, эцэг эх хувьд болон итгэмжлэлийн дагуу оролцсон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 19-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай 04 дугаартай тогтоолоор томилогдсон Тооллогын комиссын 2024.04.29-ны өдрийн 01 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурал хүчин төгөлдөр болсон тухай тогтоолыг Тооллогын комиссын дарга Т.Ууганцэцэг уншиж танилцуулав.

Тогтоолд: “Монгол базальт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 56,417,000 ширхэг хувьцаа эзэмшдэг 2420 хувьцаа эзэмшигчдээс 47 хувьцаа эзэмшигч ирж хуралд оролцсон нь 39,756,853 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 70.47% болж Хувьцаа Эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээж, хуралд биечлэн оролцож буй бусад зочдыг танилцуулав.

Хурлын дарга П.Нямдорж: Сайн байцгаана уу. Цаг заваа зориулан хуралдаа ирсэн та бүхэндээ баярлалаа. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчидээс гадна Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ш.Энхтөр, Ч.Зоригтбаатар, П.Нямдорж, ердийн гишүүн Б.Шаравсамбуу, Г.Ганзориг нар, Хөндлөнгийн аудит хийж дүгнэлт гаргасан “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК-ийн ахлах аудитор Мягмарцэрэн, Үнэт цаасны Апекс монголиа ХХК-ийн төлөөлөгч Н.Цэнд-Аюуш нар хүрэлцэн ирсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хувьцаа эзэмшигчдийн танилцах материал болон Компанийн 2023 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг нэгтгэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал бэлтгэн хэвлүүлж брокер, диллерийн компаниар дамжуулан хүргүүлсэн ба компанийн цахим хуудас байршуулсан байсан. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан хэлэлцэх асуудал, дэгийн дагуу хурлаа үргэлжлүүлэе.


Хэлэлцэх асуудал №1:

Монгол базальт ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл: ТУЗ-ийн дүгнэлт хэлэлцэж батлахтай холбогдуулан компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, цаашид хийгдэх ажлуудыг ерөнхийд нь танилцуулъя. Бид хувьцаа эзэмшигчдэд зориулж үйл ажиллагааны тайланг видео хэлбэрт оруулсан байгааг үзүүлбэ.

Видео бичлэг холбоос: <https://www.youtube.com/watch?v=AA4TZaIDlxc>

Дэлгэцийн харагдах байдал товч:



Компанийн хараат бус хөндлөнгийн аудитын компанийг “Нексия Глобал монголиа аудит” ХХК-ийг ТУЗ-өөс сонгож, гэрээ байгуулан компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан аудит хийж дүгнэлт гаргасан. “Нексия Интернэшнл” гэдэг дэлхийд ТОП-8 ордог аудит, нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээний тэргүүлэгч компанийн Монгол Улс дахь албан ёсны хараат бус гишүүн байгууллагаар ажилладаг ба манай компанийн хараат бус хөндлөнгийн аудитын дүгнэлт нь Англи, Монгол хэл дээр СТОУС-ын дагуу хийгдэж гарсан, энэ нь компанийн цаашдын хэрэгжүүлэх олон улсын төсөл, санхүүжилтэд чухал ач холбогдолтой юм. Мөн өнөөдрийн ХЭХ дээр хөндлөнгийн аудитын компанийн төлөөлөгчөөр ахлах аудитор Мягмарцэрэн хүрэлцэн ирсэн ба та бүхэн сонирхсон асуултаа асууж болохоор байгаа шүү. Та бүхэн компанийхаа үйл ажиллагаатай байнга танилцаж, нээлттэй мэдээлэл байнга авч байгаа гэдэгт найдаж байна.

Хурлын дарга П.Нямдорж: 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн товч мэдээллийг үзэж танилцлаа. Одоо та бүхэнд Тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг ТУЗ-ийн гишүүн, гавъяат эдийн засагч Б.Шаравсамбуу танилцуулна.

ТУЗ-ийн гишүүн Б.Шаравсамбуу: Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлбэ. Манай компани 2023 онд түүхэнд үлдэх томоохон өөрчлөлт шинэчлэлт, технологи хөгжүүлэлтийг хийж чадсан жил байлаа. Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 6 удаа 100 хувийн ирцтэй хуралдаж 21 тогтоол, шийдвэр гаргаж

ажилласан ба ТУЗ-ийн дэргэд Эрсдлийн удирдлагын хороог шинээр зохион байгуулан ажиллаж байна. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн бодлогын хэд хэдэн баримт бичгүүдийг боловсруулж баталгаажуулсан, үүнд: Бизнесийн ёс зүйн дүрэм, Эрсдлийн удирдлагын хороо байгуулагдсантай холбогдуулан үйл ажиллагааны журам, бусад журамд нэмэлт өөрчлөлт оруулах болон Залгамж халааны бодлого, Цалин урамшууллын бодлого, Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого зэргийг баталсан байна. ТУЗ-ийн үйл ажиллагааг дүгнэх чухал үзүүлэлт нь Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээ байдаг. Энэхүү үнэлгээг компани өөрөө хийж, Санхүүгийн зохицуулах хорооноос хянан баталгаажуулдаг ба бид 2023 оны 8 сарын байдлаар 88,9 хувь буюу 104 компанийн үнэлгээнээс арвандөрөвдүгээрт эрэмлэгдсэн юм. Мөн 2024 оны 04 сарын 01-ний байдлаар энэхүү үнэлгээг дахин хийхэд 71 оноос буюу 98.6 хувийн үнэлгээтэй байна. Компанийн тухай хуульд зааснаар Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, хэлэлцүүлдэг журамтай байгаа. Иймд ТУЗ-ийн дүгнэлтийг та бүхэнд уншиж танилцуулъя.

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТУЗ-ӨӨС 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

“Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан компанийн дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

2022 онд Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Компанийн хэвийн үйл ажиллагаанд эрсдэл үзүүлэх сөрөг хүчин зүйлүүд болох тээвэр ложистикийн хомсдол, дотоод болон гадаадын бараа материалын үнийн өсөлт, ААН-үүдийн төлбөрийн чадварын бууралт, томоохон төслүүдийн царцалт, валютын ханшийн өсөлт зэрэг асуудлуудтай олон сар нүүр тулсан хэдий ч бид онцгой цаг үеийн бодлого баримталж зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахаар барилгын дулаан тусгаарлагч байгальд ээлтэй чулуун хөвөн хавтан үйлдвэрлэж эхний хагас жилд 2020 оны үйлдвэрлэлтэй тэнцэх хэмжээний бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлсэн бол 2021 оны эцэст бизнес төлөвлөгөөнд тусгасан үйлдвэрлэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. Энэхүү үйлдвэрлэлийн өсөлт нь эхний улиралд хийгдсэн томоохон капитал хөрөнгө оруулалт болох хөвөн шарах камерийн технологийн шинэчлэлийн ажлын үр дүн байв.

2021 онд базальт лайт маркийн чулуун хөвөн хавтанг зах зээлд шинээр нэвтрүүлэн хэрэглэгчийн гарт хүргэсэн ба Стратегийн томоохон ач холбогдол бүхий байгууллагууд болох ДЦС-2 ТӨХК, ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК, УБДЦС ТӨХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ДЦС, Эрдэнэтийн ДЦС, Таван толгой түлш ХХК-д шугам хоолон дулаалга, төмөр торон бүрээстэй оёмол хөнжил зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн нийлүүлж чулуун хөвөн дулаалгын материал үйлдвэрлэх дотоодын цор ганц үйлдвэр гэдгээ баталж чадсан.

Гүйцэтгэх удирдлагын баг цаг үеийн нөхцөл байдалд зохицсон санхүү болон үйлдвэрлэл үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт хийн компанийн цаашдын үйл ажиллагааг тогтвортой байлгах бизнес төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл явуулахыг нэн тэргүүний зорилгоо болгон ажиллаж үйл ажиллагааны зардлаа 2020 онтой харьцуулахад ---%-иар бууруулан, борлуулалтын орлогоо 3.5 дахин, цэвэр ашигаа 11.7 дахин тус тус өсгөсөн амжилттайгаар 2022 оныг угтаж байна.

“Монгол базальт” ХК 2021 онд нийгмийн хариуцлагын хүрээнд олон төсөлт ажлуудыг зохион байгуулж, санхүүжүүлж оролцсоноос Өсвөрийн хоккейн улсын аварга шалгаруулах “Basalt cup 2021” уралдаан, “Мөрөөдөл биелдэг юм” хандив тусламж зэргийг дурьдаж болох юм.

Мөн тасралтгүй инноваци, судалгааны үр дүнд Хөрсгүй тариалалт буюу "Базальт Чулуун Хөвөн ашиглан ургамал тарих" гарын авлага ном гаргаж, Мишээл худалдааны төвд Showroom байгуулан экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, эко бүтээгдэхүүн хэрэглэх хүсэлт, зорилго бүхий хүмүүсийн хэрэгцээг хангахад гар бие оролцож байна.

Энэ бүгдээс дүгнэхэд Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг нь цаг үеийн нөхцөл байдалд тохируулан санхүү болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт хийж 2021 оны бизнес төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж чадварлаг ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна” ТУЗ гэсэн дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Хурлын дарга П.Нямдорж: Хурлын дэгийн дагуу дараагийн танилцуулах мэдээлэл нь ногдол ашгийн талаарх танилцуулга байгаа. Монгол базальт ХК-ийн ТУЗ 2024 оны 02 сарын 16-ны өдөр буюу санхүүгийн жил дууссанаас 50 хоногийн дотор буюу хуулийн хугацаанд хуралдаж Хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байгаа. Компанийн 2023 оны жилийн эцсийн аудитлагдаагүй тайлангийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 21 төгрөг буюу 1,184,757,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосон байгаа. Тэгэхээр хуралдаа оролцож буй та бүхэн бүгдээрээ ногдол ашиг авах боломжтой байна. Монголын хөрөнгийн бирж дээр 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг тарааж байгаа 43 орчим компани байгаагаас ногдол ашгийн өгөөж буюу одоо байгаа хувьцааны ханш, өгч буй ногдол ашгийн хэмжээгээр Монгол базальт ХК гуравдугаарт жагсаж байгаа. 1-т Таван толгой ХК, Хаан банк тэгээд манай компани байгаа юм. Өмнөх жилүүдэд ч 12-15 хувийн өгөөжтэйгээр ногдол ашгийг тарааж байна. Сүүлийн 3 жилд ногол ашгийг тогтмол өссөн дүнгээр тарааж байгаа, цаашид ч тараах боломжтой байгаа нь манай компанийг хөрөнгө оруулалтын өндөр өгөөжтэй компани юм аа гэдгийг харуулж байгаа чухал үзүүлэлт юм.

Дараагийн хэлэлцэх асуудал бол компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт танилцуулах байгаа. Энэ асуудлыг гүйцэтгэх захирал А.Энхгэрэл танилцуулна.

Хэлэлцэх асуудал №2:

Монгол базальт ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл: Компанийн дүрмийн 6 дугаар бүлэг 6.2.2-т “Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна” өөрчлөх санал байгаа, өмнөх дүрэмд 2 жил байсныг 4 жил болгож өөрчлөх санал оруулж байна. Энэ нь компани БОНЗ-ын үнэлгээ хийлгэсэнтэй холбогдуулан компанийн үйл ажиллагаа, комплайнс, засаглалыг тогтвортой барьж ажиллуулах, дор хаяж 4-өөс дээш жил ажиллуулах, нэг төрлийн үнэ цэнийг бий болгох, үр дүнд хүрэх хугацааг 2 жил хангалтгүй гэж үзсэн бөгөөд 4 буюу түүнээс дээш жил байх нь компанийн үйл ажиллагааг тогтвортой хангах боломжтой бодлого боловсруулах, түүний үр дүнг харах боломжтой гэж үзэж байна.

Ажилтнуудын хувьцаажуулах хөтөлбөрийн тухай ТУЗ-ийн гишүүн Нямдорж та танилцуулга хийнэ үү.

Хурлын дарга П.Нямдорж: Ажилтнуудыг хувьцаажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа. Сүүлийн жилүүдэд ажилтнуудын тогтвортой байдал, мэргэжил ур чадварыг, мэргэжилтэй ажилтныг тогтвортой ажиллуулах, хөгжүүлэх нь тулгамдсан асуудал болоод байна. Монгол базальт ХК нь нээлттэй хувьцаат компани байгаагийн давуу талаа ашиглан ажилтнуудаа хувьцаажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн, энэ нь хэд хэдэн ач холбогдолтой байна.

1. Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах- сайн мэргэжилтэй ур чадвартай ажилтнуудыг хадгалж үлдэх, одоо ажилтнуудад мөнгөн хэлбэрээр өгч байгаа урамшууллын тодорхой хэсгийг хувьцаа хэлбэрээр өгөх нь хувьцааны ногдол ашиг авах, ханшийн өөрчлөлтийн өгөөжийг хүртэх ач холбогдолтой юм.
2. Ажилтнууд компанийн эцсийн өмчлөгчдийн нэг болж байгаа тул ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандах, бүтээмж дээшлэх, тогтвортой ажиллах гэсэн давуу талтай.
3. Мөн хувьцааны эрэлт үүснэ. Хоёрдогч зах зээл дээрээс хувьцаа худалдан авч ажилтнуудад эзэмшүүлэх тул хувьцааны ханшийн өөрчлөлтийг өсгөхөд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

Энэхүү хөтөлбөрийг ТУЗ-д танилцуулсан, өнөөдрийн хуралд танилцуулж байна. Цаашдаа энэ ондоо багтаан хийж хэрэгжүүлэх ажлуудын нэг юм.

Ажилтнуудыг хувьцаажуулах нь нэг талаас ажилтнуудын тогтвортой ажиллах боломж, хүсэл зоригийг нэмэгдүүлэхээс гадна компани урт хугацаандаа тогтвортой ажиллах боломжийг олгодоггоороо маш чухал давуу талтай юм. Мөн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг ур хугацаанд хүртэх боломжийг улам баталгаажуулах юм гэдгийг та бүхэн ойлгоорой.

Мөн компанийн хэрэгжүүлж буй дараагийн арга хэмжээ бол хөрөнгө оруулагчдыг халамжлах хөтөлбөр буюу Investor relations хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр холбогдох ажлуудыг хийж, зарим хамтран ажиллах байгууллагуудтай гэрээ байгуулсан байна. Та бүхэн мэдэж байгаа анх хувьцаа гаргахад 300 гаруй төгрөг байсан, одоо зах зээл дээр 200 орчим төгрөгийн ханштай болчлоо гэж нилээд хэл ам хийдэг. Энэ маань компани болон ХЭ-ийн хооронд мэдээллийн солилцоо дутуу байгаагаас болдог. Мөн компани хичнээн үйл ажиллагаа сайн байгаад, ногдол ашгийг тогтмол, өндөр өгөөжтэйгээр тараасан ч хувьцааны ханш өсөхгүй байгааг хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээлэл зөв сувгаар хүрч чадахгүй байна уу гэсэн ойлголт байгаагаас энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр эхлүүлж байна. Энэ намраас судалгааны ажлууд дуусч хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нартай нилээд ойртож мэдээлэл дамжуулах, хамтран ажиллаж эхлэнэ, энэ нь компаний үнэ цэнийг өсгөж хувьцааны ханшийг ч өөрчлөхөд дөхөм болно гэж харж байгаа.

Хурлын дарга П.Нямдорж: Хурлын дэгийн дагуу цайны завсарлага байгаа, гэхдээ хурлаар хэлэлцэх гол асуудлуудаа танилцуулаад цайны завсарлага хийх саналтай байна. Ингээд Монгол базальт ХК-ийн дунд хугацааны хөгжлийн бодлого танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн дарга Л.Ариунболд таныг индэрт урьж байна.

ТУЗ-ийн дарга: Л.Ариунболд: Сайн байцгаана уу, эрхэм хувьцаа эзэмшигч та бүхний энэ хаврын мэндийг хүргэе. Сайхан хаваржиж байна уу? Өнөөдөр уламжлал ёсоор манай компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болж байна. Манай компани бол хүнд аж үйлдвэрийн металл бус хүнд

үйлдвэрийн салбарт нийт 30-аа жил ажиллаж байна. Би хэд хэдэн асуудлыг тодотгож хэлье гэж бодож байна. Анх нээлттэй хувьцаат компани болж байхад манай үйлдвэрийн хүчин чадал 1 тонн байсан, 5 жилийн хугацааны хөгжлийн бодлого бол хүчин чадалаа 1.5 тонн болгоно гэсэн зорилт тавьж байсан. Өнөөдөр бол жилийн хугацааны үйлдвэрийн дундаж хүчин чадал 2.5 тонн болсон амжилттай байна. Манай хөрш Орос, Хятад улсад 1 тонн бүтээгдэхүүн хөгжүүлэхэд 1 сая долларын хөрөнгө оруулалт шаардагддаг гэж үнэлгээгээр харьцуулахад 15-20 сая долларын хөрөнгө оруулалт хийгдэж өнөөдрийн 2.5 тонн хүчин чадалд хүрсэн байна. Энэ ажил маань нэг өдрийн ажил биш 2020 оноос хойш урт хугацаанд хэрэгжүүлж, зуухны гарцыг нэмэгдүүлэх хэрээр үйлдвэрийн бүх шугам дамжлагын хүчин чадлыг үе шаттай нэмэгдүүлж, инженерийн шийдлүүдийг хийж явсан нь нэг талдаа амжилт, нөгөө талдаа үр дүнгээр баталгаажих боломж олгосон гэдгийг хэлэх нь зүйтэй юм. Бусад орнуудад болон үйлдвэрлэлийн технологийн шинэчлэл хийхэд шугам дамжлага, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг бүхэлд нь сольдог бол бид урт хугацааны инженерийн шийдэл гаргаж ажилласан, мөн манай инженер техникийн ажилтнууд, гадны сайн инженерүүдтэй хамтран ажилласны үр дүнд 2023 оны 9 сард энэхүү амжилтыг гаргаж чадаад зах зээл дээр 51 хувийн үнийг бууралт хийж чадсан байна. Үнэ хямдарсан гэхээр хүмүүс дэлгүүрийн огцом хямдрал шиг түр зуурын гэж ойлгодог, харин технологийн хөгжил, дэвшилт, өөрчлөлтөөр хийсэн хямдрал нь урт хугацаандаа байх боломжтой өөрчлөлт юм гэдгийг тодруулж хэлэхийг хүсч байна.

Хэлэлцэх асуудал №3:

Компанийн дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулж, батлах, хэрэгжилтийг нь хангах зөвшөөрөл олгох тухай

Дэлгэцийн харагдах байдал

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ-3

МОНГОЛ БАСАЛТ ҮХ-ийн дунд хугацааны хөгжлийн бодлого /20 минут/

Ирэх таван жилийн хугацаанд жилийн орлогын өсөлтийн хурдыг дор хамж 20-30%-д хүргэж, сүүлийн таван жилд тохиолдсон жилийн хамгийн багадаа 25%-иар тогтмол нэмэгдэхэд тулгуурлана.

ОРЛОГЫН ӨСӨЛТ

Компанийн судалгаа хийж, үйл ажиллагааны болон үйлдвэрлэлийн дэвшилийг үндсэнд нь чиглүүлж шинэ технологийг анхнаар хэрэглэж байсантай үзүүлж 2025 оны эцэс гэхэд одоо байгаа үйлдвэрлэлийн хүчин чадлыг гурав дахин нэмэгдүүлнэ.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Эрчим хүчний хэмжээтэй технологи, тогтвортой дулаалтын шийдлүүдийн чиглэлээр компанийн туршлагыг ашиглан шинэ баазыг байр барих зээлд амжилттай нэвтрэх, байр сууриа бий болгоно.

ШИНО ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХ

Нүүрсгэрлэлийн ялгаруулалтыг бууруулах, хөгжлийг бууруулах, тогтвортой дулаалтын шийдлүүдийг боловсруулахад анхны тогтвортой байдлын санхүүжилтүүдийг хэрэгжүүлж, эцэс дэвшилийг хангана.

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН САНААЧЛАГА

ПАССИВ ХАУС

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ХАУС ТӨСӨЛ

Манай дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрийн товч мэдээлэл танилцуулав. Манай компани нэг төрлийн суурилагдсан үйлдвэр тоног төхөөрөмжийг дагнан хөгжүүлж байгаа компани, бусад аж ахуйн нэгжүүд шиг олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, чадахгүй аливаа нэгэн салбарт ажиллаж эрсдэл үүрэхгүй байхыг хичээж ажилладаг. Энэ маань мэдээж сайн болон сул салтай. Яагаад гэвэл мөнгө олж, эрэлт ихтэй зах зээлд орж ажиллахгүй, үйлдвэр технологи хөгжүүлэлт хийж үр дүнд хүрнэ гэдэг нь цаг хугацаа шаардсан ажил байдаг. Нөгөө талдаа нэг салбараа дагнан хөгжүүлж байгаа нь ажиллах хүчний чадамжийг хөгжүүлэхэд илүү түлхэц өгч байгаа юм.

Дараагийн томоохон төсөл бол фибер бүтээгдэхүүний зах зээлд орж ажиллахаар судалгаа шинжилгээний ажил хийгдэж байна. Дэлхийн хөгжлийн дараагийн том эрин, шинэ материалын хамгийн том эрин ирж байна. Бид саяхан Франц улсад болсон Файбер материалын том үзэсгэлэнд оролцож ижил төстэй компаниудаар орж туршлага судлаад ирсэн. Файбер материалын хамгийн том хэлбэр нь арматур байгаа, арматурыг бид сүүлийн 5 жилд судалж, хөгжүүлсэний үр дүнд 2022 онд Файбер арматурын үйлдвэрийг ашиглалтад оруулж, 2023 онд тогтвортой үйлдвэрлэл явууллаа. Энэ технологийг бид эзэмшиж чадсан учраас базальт фибер труба хийх, эрчим хүчний 36 к.Вт-ын шугамын шонгуудыг базальт фибераар хийх технологийн судалгааны ажлыг эхлүүлсэн байна.

Үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж байгаатай холбогдуулан уламжлалт ганц бүтээгдэхүүн борлуулах биш, цаашид дунд хугацааны хөгжлөөр үйлдвэрээс гарч буй бүтээгдэхүүнийг бусад бүтээгдэхүүнд ашиглаж үйлдвэрлэл, борлуулалт хийх ажлуудыг хөгжүүлэх юм.

2023 онд Дархан-Уул аймагт лаборатори Пассив байшин барьж ашиглалтад оруулсан. Энэ пассив байшингийн материалыг үйлдвэрлэх нь дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгагдах нэг хөтөлбөр юм. Пассив байшингийн эрэлт зах зээл дээр их байгааг та бүхэн бүгд мэдэж байгаа, бид үндсэн дулаалгын материалыг үйлдвэрлэж байгаа учир бусад материалуудыг бэлтгэж хамгийн хямд үнээр үйлдвэрлэх, мөн хамгийн чанартай зузаан байдлаар үйлдвэрлэж чадна гэж үзэж байна. Мөн хэсэгчлэн угсрах сэндвич хавтангийн үйлдвэрийг барьж, ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Бидний хамгийн их цаг хугацааг авч байгаа зүйл бол технологи, инновацийн судалгаа, хөгжүүлэлт юм. Энэ хэмжээгээрээ үйл ажиллагааны зардлын тодорхой хувийг эзэлж байна.

Файбер утасны зах зээлд орж, энэ төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж чадвал экспортын маш өндөр зах зээл хүлээж байгаа тул бид судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Ойрын ирээдүйд фибер утасны үйлдвэрлэлийг хийх боломж байгаа гэж харж байгаа тул дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгах саналтай байна.

Хурлын дарга П.Нямдорж: За технологи инноваци хөгжүүлэлттэй холбоотой компанийн дунд хугацааны хөгжлийн бодлогыг танилцуулсан ТУЗ-ийн дарга Л.Ариунболд таньд баярлалаа.

Одоо цайны завсарлагын үеэр та бүхэн сонирхсон асуултаа асууж, хариулт авч болно.

Хурлын дарга П.Нямдорж: Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт байхгүй бол санал хураалтаа явуулж, хурлын шийдвэрээ нэгтгэе.

Тооллогын комиссын дарга Т.Ууганцэцэг: Санал хураалтын хугацаа дууслаа. Санал хураалтын дүнг танилцуулъя. 2023.04.17-ны өдрийн Тооллогын комиссын тогтоол дугаар 2 уншиж танилцууллаа. Үүнд:

Компанийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалт, 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол базальт” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах эсэх: нийт 39,701,321 ширхэг хувьцааны 40 хувьцаа эзэмшигч санал өгсөнөөс зөвшөөрсөн 39 хувьцаа эзэмшигч буюу 39,698,247 ширхэг хувьцаа, татгалзсан 1 хувьцаа эзэмшигч буюу 3074 ширхэг хувьцаа ба санал өгсөн хувьцаа эзэмшигчид 99.9% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.
2. “Монгол базальт” ХК-ийн дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулж, батлах зөвшөөрөл олгох эсэх: нийт 39,701,321 ширхэг хувьцааны 40 хувьцаа эзэмшигч санал өгсөнөөс зөвшөөрсөн 39 хувьцаа эзэмшигч буюу 39,698,247 ширхэг хувьцаа, татгалзсан 1 хувьцаа эзэмшигч буюу 3074 ширхэг хувьцаа ба санал өгсөн хувьцаа эзэмшигчид 99.9% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.
3. “Монгол базальт” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах батлах эсэх: нийт 39,701,321 ширхэг хувьцааны 40 хувьцаа эзэмшигч санал өгсөнөөс зөвшөөрсөн 39 хувьцаа эзэмшигч буюу 39,698,247 ширхэг хувьцаа, татгалзсан 1 хувьцаа эзэмшигч буюу 3074 ширхэг хувьцаа ба санал өгсөн хувьцаа эзэмшигчид 99.9% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.

Тооллогын комиссын дарга Т.Ууганцэцэг гэжээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн нь:

Нэгдүгээр асуудал: Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлтийг батлах,

Хоёрдугаар асуудал: “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.2 дах хэсгийн “2 жил” гэснийг “4 жил” болгон дараах байдлаар өөрчлөх, *“Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна”*

Гуравдугаар асуудал: “Монгол Базальт” ХК-ийн дунд хугацааны хөгжлийн бодлогыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн гаргасан санал, дүгнэлтийг тусган боловсруулж, баталгаажуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрөх

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Билгүүн



